

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/25/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023  
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: [byambasurend@audit.gov.mn](mailto:byambasurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт .....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.28 № 01/221  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.БАТЧИМЭГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 46 зорилт 192 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 94,9%-тай буюу "Үр дүнтэй" гэж дүгнэсэн байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Төв аймгийн Мөнгөнморьт сумын ИТХ-ын 2023 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Мөнгөнморьт сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

Тайлант онд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 688,454.0 мянган төгрөгийн сумын гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажил, айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн дулаанд холбох ажил, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар ЗДТГ-ын авто машины парк шинэчлэл, усны болон хог тээвэрлэх машин, сумын төвийн хөрсний бохирдол бууруулах зорилгоор 11 байрлалд 54 кабин бүхий эко нойл, сумын төвийн хуучин хогийн цэгийг дарж булж, шинээр 100х50 хэмжээтэй шинэ хогийн цэгийг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 361,638.3 мянган төгрөгийн Соёлын төвийн тохижилт холболтыг шинэчлэн засварлах, сумын усан сангийн их засварын ажил, наадмын талбай, Соёлын төвийн зураг төслийн ажил хийж гүйцэтгэн, Сумын 100 жилийн ойн арга хэмжээнд 273,336.1 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн зарцуулсан байна.

G/Архив/Албан бичиг 2024/ А4

01000521

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,050,411.4	1,335,915.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,642,455.1	830,061.4
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	309,670.6	369,606.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	98,285.7	136,248.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,817,526.4	4,018,563.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,817,526.4	4,018,563.1
39200	Биет хөрөнгө		2,776,083.2	3,917,462.4
39300	Биет бус хөрөнгө	13	41,443.2	101,100.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,867,937.8	5,354,478.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		12,430.5	4,449.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	12,430.5	4,449.4
41300	Өглөг	17а, 17б	12,430.5	4,449.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,855,507.3	5,350,029.2
51	Засгийн газрын хувь оролцоо		4,855,507.3	5,350,029.2
51100	Засгийн газрын оруулсан капитал		668,984.8	668,984.8
51200	Хуримтлагдсан үр дүн		3,985,513.7	4,480,035.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		201,008.8	201,008.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,867,937.8	5,354,478.5

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,191,399.1	2,619,319.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,659,720.5	784,286.8
110	Орлогын албан татвар		249,408.2	265,952.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		260,260.7	277,952.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-10,852.4	-12,000.0
113	Хөрөнгийн албан татвар		18,503.2	25,073.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		1,391,809.2	493,261.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	515,691.4	127,516.5
120	Нийтлэг татварын бус орлого		515,691.4	127,516.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,015,987.2	1,707,516.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,846,700.1	2,124,797.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,282,054.6	1,609,086.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,241,078.4	1,555,227.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		347,945.5	511,338.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		44,342.4	65,451.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		378,377.5	430,397.9
2104	Хангамж, бараа материалын зардал		64,694.6	66,852.6
2105	Нормативт зардал		41,805.1	10,428.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,840.0	11,571.8
2107	Томиллот, зочны зардал		4,268.2	8,073.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,011.2	4,928.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		344,794.0	446,184.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		40,976.1	53,858.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		564,645.6	515,711.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,344,699.0	494,521.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,357,324.3	0.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-2,012,625.3	494,521.8

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,921,570.9	6,921,570.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-53,438.3	-53,438.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,868,132.6	6,868,132.6
9	Тайлант үеийн үр дүн	-2,012,625.3	-2,012,625.3
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,855,507.3	4,855,507.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,855,507.3	4,855,507.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,855,507.3	4,855,507.3
19	Тайлант үеийн үр дүн	494,521.8	494,521.8
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	5,350,029.2	5,350,029.2

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,733,546.0	2,631,305.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,606,822.9	784,286.8
110	Орлогын албан татвар	196,510.6	265,952.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	207,363.1	277,952.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-10,852.4	-12,000.0
113	Хөрөнгийн албан татвар	18,503.2	25,073.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,391,809.2	493,261.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,131.6	10,200.4
1181	Газрын төлбөр	2,362.5	86,709.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,380,315.1	396,351.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	110,473.6	412,880.3
120	Нийтлэг татварын бус орлого	110,473.6	139,502.2
122	Тусламжийн орлого	0.0	273,378.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,016,249.4	1,434,137.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,012,270.8	2,031,003.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,012,270.8	2,031,003.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	969,982.6	1,977,144.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	326,310.1	514,339.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,416.6	64,966.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	382,419.3	78,710.4
2104	Хангамж, бараа материалын зардал	35,760.4	44,957.0
2105	Нормативт зардал	41,812.2	10,428.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,340.0	7,013.0
2107	Томилолт, зочны зардал	3,572.2	6,843.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,695.0	376,197.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,656.7	873,689.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,288.2	53,858.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,721,275.2	600,302.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	747,852.1	1,352,379.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	747,852.1	1,352,379.7
2200	Дотоод эх үүсвэрээр	747,852.1	1,352,379.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-747,852.1	-1,352,379.7
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,508.0	-60,316.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,508.0	60,316.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	971,915.1	-812,393.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	670,540.0	1,642,455.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,642,455.1	830,061.4

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,801,362.2</b>	<b>3,111,583.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,035,538.8</b>	<b>1,889,267.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,009,148.2</b>	<b>1,862,879.2</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	506,770.2	495,446.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,345.9	62,568.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	460,430.9	421,958.6
2104	Хангамж, бараа материалын зардал	34,123.1	33,615.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000.0	11,571.8
2107	Томилолт, зочны зардал	6,856.6	6,843.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,327.0	19,941.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	899,294.5	810,935.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>26,390.6</b>	<b>26,388.6</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,390.6	26,388.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,625,823.4</b>	<b>1,162,000.0</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>140,000.0</b>	<b>60,316.0</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,801,362.2</b>	<b>3,183,298.6</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>496,590.8</b>	<b>484,159.2</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,069,038.8</b>	<b>2,372,830.3</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>735,732.6</b>	<b>52,931.0</b>
<b>36</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	<b>500,000.0</b>	<b>273,378.1</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	132,258.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	203,973.4
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>61</b>	<b>61</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>3</b>	<b>3</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>29</b>	<b>29</b>
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>29</b>	<b>29</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>76,010.4</b>	<b>328,407.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>76,010.4</b>	<b>328,407.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>38,362.0</b>	<b>289,847.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	18,893.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,398.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,654.1	11,004.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,878.3	11,342.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	220.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.0	726.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,529.7	245,262.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,648.3	38,560.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,340.1	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,308.2	38,560.3
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>75,748.1</b>	<b>328,407.4</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>75,748.1</b>	<b>328,407.4</b>
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>(262.3)</b>	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	262.3	-

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга нь орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга төрийн хуулийг дээдлэн хүндэлж иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй, ил тод, нээлттэй хүргэн ард иргэдийнхээ амьжиргааны түвшин дээшлүүлэх замаар сум орон нутгаа хөгжүүлэхэд оршино гэсэн зорилт тавин ажилласан байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Төв аймгийн Мөнгөнморьт сумын ИТХ-ын 2023 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Мөнгөнморьт сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Тайлант онд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумын гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажил 91,500.0 мянган төгрөг, айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн дулаанд холбох ажил 79,954.0 мянган төгрөг, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар ЗДТГ-ын авто машины парк шинэчлэл, усны болон хог тээвэрлэх машин 178,000.0 мянган төгрөг, сумын төвийн хөрсний бохирдол бууруулах зорилгоор 11 байрлалд 54 кабин бүхий эко нойл 282,000.0 мянган төгрөг, сумын төвийн хуучин хогийн цэгийг дарж булж, шинээр 100х50 хэмжээтэй шинэ хогийн цэгийг 57,000.0 мянган төгрөгөөр тус тус бүтээн байгуулалтыг хийсэн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Соёлын төвийн тохижилт холболтыг шинэчлэн засварлах ажлыг 329,638.3 мянган төгрөг, сумын усан сангийн их засварын ажил 20,000.0 мянган төгрөг, наадмын талбай, Соёлын төвийн зураг төсөл 12,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 46 зорилт 192 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 94,9%-тай буюу “Үр дүнтэй” гэж дүгнэсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн "Дотоод хяналтын зөвлөл шинэчлэн батлах тухай" А/193 захирамжаар томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын дотоод хяналтын зөвлөл нь тайлант онд дотоод хяналт шалгалтыг улирлаар төлөвлөн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга 2021 онд батлагдсан 5 бүлэг бүхий Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 486,540.8 мянган төгрөгөөр буюу 10,0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,642,455.1	830,061.4	(812,393.7)
Авлага	309,670.6	369,606.0	59,935.4
Бараа материал	98,285.7	136,248.0	37,962.4
Үндсэн хөрөнгө	2,817,526.4	4,018,563.1	1,201,036.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,867,937.8</b>	<b>5,354,478.5</b>	<b>486,540.8</b>
Өр төлбөр	12,430.5	4,449.4	(7,981.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,855,507.3	5,350,029.2	494,521.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,867,937.8</b>	<b>5,354,478.5</b>	<b>486,540.8</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 812,393.7 мянган төгрөгөөр буурч 830,061.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Тайлант онд орон нутгийн орлого 622,550.3 мянган төгрөг нь давсан орлогын үлдэгдэл, орон нутгийн хөгжлийн сан 145,302.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын хийгдээгүй ажлын үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сан 58,671.1 мянган төгрөг нь шалгаруулалтад тэнцсэн төслийн материал ирүүлээгүй үлдэгдэлд 3,537.7 мянган төгрөгийн эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 369,606.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 59,935.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газар 33,743.9 мянган төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хурал 2,470.8 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 29,394.7 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 1,287.5 мянган төгрөгийн авлага үүссэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 136,248.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 37,962.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газар 33,580.3 мянган төгрөг, Ойн анги 3,600.0 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 451.5 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 330.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,018,563.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,201,036.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газар 1,193,422.6 мянган төгрөг, Ойн анги 3,283.5 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 1,174.7 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 3,155.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй болон худалдан авснаас шалтгаалсан байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 12,430.5 мянган төгрөг, эцсийн

үлдэгдэл 4,449.4 мянган төгрөг болж 7,981.1 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд Засаг даргын Тамгын газрын 4,000.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 449.3 мянган төгрөгийн өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ нь 5,350,029.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 494,521.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 830,061.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 812,393.7 мянган төгрөгөөр буюу 50,5 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	1,642,455.1	830,061.4	(812,393.7)
Төгрөг	1,642,455.1	830,061.4	(812,393.7)
Төрийн сангийн харилцах	1,637,725.9	826,523.6	(811,202.2)
Арилжааны банк дахь харилцах	4,729.2	3,537.8	(1,191.5)
<b>Дүн</b>	<b>1,642,455.1</b>	<b>830,061.4</b>	<b>(812,393.7)</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн хөрөнгийн тодруулга тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 830,061.4 мянган төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 826,523.6 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 3,537.8 мянган төгрөг байршиж байна. Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 826,523.6 мянган төгрөгийн 75,3 хувь буюу орон нутгийн ерөнхий орлогын 622,550.3 мянган төгрөг, 17,6 хувь буюу Орон нутгийн хөгжлийн сангийн 145,302.2 мянган төгрөг, 7,1 хувь буюу Хоршоо хөгжүүлэх сангийн 58,671.1 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл нь 812,393.7 мянган төгрөгөөр буюу өмнөх оноос орон нутгийн төсвийн орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 882,917.0 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 10,017.9 мянган төгрөгөөр буурч, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 81,733.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Арилжааны банк дахь харилцах данс буюу эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 1,191.6 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Аудитын илрүүлэлт

1. Төв аймгийн Мөнгөнморьт сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01 тоот "Цалин шинэчлэн тогтоох тухай" тушаалаар төрийн албаны улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 2,525.3 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт бичив.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 369,606.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 59,935.4 мянган төгрөгөөр буюу 19,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	6,960.9	34,268.0	27,307.1
Хувь хүмүүсээс авах авлага	302,709.7	335,338.1	32,628.4
<b>Дүн</b>	<b>309,670.6</b>	<b>369,606.0</b>	<b>59,935.4</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн авлагын тодруулга тайлан

Авлагын үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн 332,103.7 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 89,8 хувийг, байгууллагаас авах ЗДТГ-ын тракторын агрегатын эхний төлбөр шилжүүлсэн авлага 33,743.9 мянган төгрөг буюу 9,1 хувийг, ИТХ-ын НДШ-ийн илүү төлөлтийн авлага 2,470.8 мянган төгрөг буюу 0,7 хувийг, Эмийн эргэлтийн сангийн авлага 1,287.5 мянган төгрөг буюу 0,4 хувийг эзэлж байна. Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 369,606.0 мянган төгрөгийн 90,3 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 9,7 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна.

**Аудитын илрүүлэлт:**

1. Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн үндсэн зээл 167,654.4 мянган төгрөг, хүү 10,573.4 мянган төгрөг, алданги 40,293.5 мянган төгрөг нийт 218,521.4 мянган төгрөгийн авлага барагдуулах зөрчилд зөвлөмж өгөв.

**3.5.4 Бараа материал**

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 136,248.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 37,962.4 мянган төгрөгөөр буюу 38,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>22,054.0</b>	<b>21,944.5</b>	<b>(109.4)</b>
Эм боох материал	22,054.0	21,944.5	(109.4)
<b>Хангамжийн материал</b>	<b>63,731.7</b>	<b>101,803.5</b>	<b>38,071.8</b>
Бичиг хэргийн материал	5,907.4	6,851.1	943.7
Аж ахуйн материал	46,397.5	68,487.5	22,090.0
Сэлбэг хэрэгсэл	850.0	-	(850.0)
Түлш, шатах тослох материал	1,895.7	-	(1,895.7)
Хүнсний материал	-	1,002.0	1,002.0
Бусад хангамжийн материал	8,681.2	25,463.0	16,781.8
<b>Мал амьтад</b>	<b>12,500.0</b>	<b>12,500.0</b>	<b>-</b>
Түүхий эд материал	22,054.0	21,944.5	(109.4)
<b>Дүн</b>	<b>98,285.7</b>	<b>136,248.0</b>	<b>37,962.4</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн бараа материалын тодруулга тайлан

Бараа материалын үлдэгдэл 136,248.0 мянган төгрөгийн 77,1 хувь буюу 105,106.9 мянган төгрөгийг Засаг даргын Тамгын газар, Ойн ангийн 3,628.0 мянган төгрөг буюу 2,7 хувийг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5,518.6 мянган төгрөг буюу 4,0 хувийг, Эмийн эргэлтийн сангийн 21,994.5 мянган төгрөг буюу 16,2 хувийг бараа материал эзэлж байна. Бараа материал данс худалдан авсан 218,439.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй 18,886.0 мянган төгрөг нийт 238,074.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 749.1 мянган төгрөгөөр хасагдсан байна.

**Аудитын илрүүлэлт: Аудитаар өгсөн алдаа, зөрчил байхгүй байна.**

**3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө**

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

**3.5.6 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,018,563.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,201,036.7 мянган төгрөгөөр буюу 42,6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>2,776,083.3</b>	<b>3,917,462.4</b>	<b>1,141,379.1</b>

Барилга, байгууламж, орон сууц	1,005,857.0	1,100,458.2	94,601.2
Авто-тээврийн хэрэгсэл	442,105.6	569,118.4	127,012.8
Машин тоног төхөөрөмж(компьютер)	60,082.0	104,578.0	44,496.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	25,054.8	42,653.1	17,598.3
Бусад үндсэн хөрөнгө	576,505.2	1,405,747.8	829,242.6
Дуусаагүй барилга, байгууламж	15,110.6	43,035.6	27,925.0
Зам гүүрний байгууламж	651,368.1	648,322.2	-3,045.9
Номын фонд		3,549.1	3,549.1
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>41,443.2</b>	<b>101,100.7</b>	<b>59,657.5</b>
Программ хангамж	515.0	3,687.5	3,172.5
Бусад биет бус хөрөнгө	40,928.2	97,413.2	56,485.0
<b>Дүн</b>	<b>2,817,526.4</b>	<b>4,018,563.1</b>	<b>1,201,036.7</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үндсэн хөрөнгийн тодруулга тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,5 хувь буюу 3,998,015.5 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,1 хувь буюу 4,113.4 мянган төгрөгийг ИТХ, 0,32 хувь буюу 12,816.7 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө, 0,08 хувь буюу 3,617.5 мянган төгрөгийн хөрөнгийг Ойн анги эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 4,018,563.1 мянган төгрөг болж, худалдан авсан 190,379.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан 267,674.0 мянган төгрөг, бусад 1,190,258.1 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, акталж устгасан хөрөнгө байхгүй байна.

**Аудитын илрүүлэлт:** Аудитаар өгсөн алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 4,449.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,981.1 мянган төгрөгөөр буюу 35,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ мянган төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	42.5	-	(42.5)
Байгууллагад төлөх өглөг	7,777.4	449.4	(7,328.0)
Хувь хүмүүст төлөх өглөг	4,610.6	4,000.0	(610.6)
<b>Дүн</b>	<b>12,430.5</b>	<b>4,449.4</b>	<b>(7,981.1)</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өглөгийн тодруулга тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Засаг даргын тамгын газрын 4,000.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 449.4 мянган төгрөг нийт 4,449.4 мянган төгрөгийн өглөг байна. Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 4,449.4 мянган төгрөг болж, 7,981.1 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан нь Засаг даргын тамгын газар 653.1 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 7,328.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:** Аудитаар өгсөн алдаа, зөрчил байхгүй байна.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,350,029.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 494,521.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

## Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	668,984.8	668,984.8	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>3,985,513.7</b>	<b>4,480,035.5</b>	<b>494,521.8</b>
Өмнөх үеийн үр дүн	5,998,139.0	3,985,513.7	(2,012,625.3)
Тайлант үеийн үр дүн	(2,012,625.3)	494,521.8	2,507,147.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	201,008.8	201,008.8	-
<b>Дүн</b>	<b>4,855,507.3</b>	<b>5,350,029.2</b>	<b>494,521.8</b>

Эх сурвалж: Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,350,029.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 494,521.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Мөнгөнморьт сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,079,509.8 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 449,834.2 мянган төгрөг, 2023 оны төсвийн жилийн урсгал үйл ажиллагааны зардлыг 2,529,344.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ойн нөөц ашигласны орлогыг 1,040,850.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 02 дугаар тогтоолд зааснаар Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд 1,321,988.6 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 710,246.5 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 393,955.2 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 67,348.0 мянган төгрөг, хандив тусламжийн орлогыг 500,000.0 мянган төгрөгөөр, сумын шилжих үлдэгдлийг 361,655.7 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн зардлыг 140,000.0 мянган төгрөгөөр нийт 3,495,194.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаар тогтоолд зааснаар Мөнгөнморьт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 1,415,684.2 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталж гүйцэтгэлээр 857,251.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 60,6 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх орлого 20,584.3 мянган төгрөгөөр үйл ажиллагааны орлого, 109.8 мянган төгрөгөөр суутган-2, хадгаламжийн хүүгийн орлого 803.5 мянган төгрөгөөр, ойн нөөцийн төлбөр 644,498.4 мянган төгрөгөөр, түгээмэл тархацтай

ашигт малтмалын албан татварын орлого 7,877.6 мянган төгрөг нийт 673,873.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

Ойн нөөц ашигласны орлогыг Мөнгөнморьт сумаас төлөвлөхдөө Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн “Хуш модны самар бэлтгэх хэмжээ тогтоох” тухай А/518 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар биологийн ургацын үнэлгээ хийхдээ Төв аймгийн Мөнгөнморьт сумыг бага гэж үнэлснийг үндэслэн 140,000.0 мянган төгрөгөөр төлөвлөн хүргүүлснийг аймгаас үндэслэлгүйгээр 900,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлэхэд анхаарч ажиллаагүй, үндэслэл муутай төлөвлөснөөс ойн нөөц ашигласны орлогыг 644,498.4 мянган төгрөгөөр, мөн өмнөх онтой харьцуулахад татварын орлогын биелэлт 5 нэр төрлөөр буурсан ч, малын тоо толгойн албан татвар, хадгаламжийн хүүгийн орлого 2022 онд 15,110.8 мянган төгрөг, 2023 онд 913.3 мянган төгрөгөөр тасалсан нь орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлсөн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 306,168.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 3,801,362.6 мянган төгрөгөөр тодотгон, шилжих үлдэгдлийн төлөвлөгөөнд 528,384.6 мянган төгрөгөөр өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 17 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,397,184.2 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 653,355.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 496,590.8 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 67,348.0 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд 100 жилийн ойн хандив, тусламжийн эх үүсвэр 500,000.0 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвараас хийгдэх хөрөнгө оруулалт 18,500.0 мянган төгрөг, сумын орон нутгийн давсан орлогоос төсвийн шилжих үлдэгдэлд 528,384.6 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 140,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,183,298.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 229,590.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Мөнгөнморьт сумын 100 жилийн ойг тохиолдуулан Төв аймгийн Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаар тогтоолоор хандив тусламжаар 500,000.0 мянган төгрөг бүрдүүлэхээр төлөвлөснөөс 273,336.1 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,111,583.8 мянган төгрөг буюу 81,9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 689,778.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь шалтгаалсан байна. Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн зардал 87,092.0 мянган төгрөгөөр хэмнэсэн нь санхүүжүүлэх орлогын эх үүсвэр дутуу, бүрдээгүйгээс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, 26 арга хэмжээнд 836,727.9 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 747,852.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-үндсэн үйл ажиллагааны зардал	92,922.4	93,410.3	(487.9)	100.5

2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	2,010,789.6	1,825,878.5	184,911.1	90.8
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	183,143.1	171,285.7	11,857.4	93.5
4	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	44,229.4	37,820.7	6,408,717.0	85.5
5	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	113,535.6	113,228.7	306.9	99.7
6	Эрүүл мэндийн төв-тогтмол зардал	44,958.7	36,724.3	8,234.4	81.7
7	Ойн анги- үндсэн үйл ажиллагааны зардал	89,344.6	76,092.0	13,252.6	85.2
8	Хоршоо хөгжүүлэх сан- үндсэн үйл ажиллагааны зардал	140,000.0	60,316.0	79,684.0	43.1
9	Орон нутгийн хөгжлийн сан-хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	1,082,438.8	696,827.7	385,611.1	64.4
	<b>Дүн</b>	<b>3,801,362.2</b>	<b>3,111,583.8</b>	<b>689,778.4</b>	<b>81.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 251,315.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 77,092.4 мянган төгрөг нийт 328,407.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 289,847.1 мянган төгрөг зарцуулж, 32,308.2 мянган төгрөг буюу Засаг даргын тамгын газар 33,265.2 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5,295.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, ИТХ, тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж, шаардлагатай мэдээллээр тасралтгүй хангахад оршино.	Сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хурлын үйл ажиллагааг тасралтгүй мэдээллээр ханган хэвийн үйл ажиллагааг ханган явуулсан байна. Хэрэгжилт 100%	92,922.4	93,410.3
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчилж хэрэгжилтийг хангах, иргэдэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй чанартай хүртээмжтэй хүргэх, ТАХ-чид хариуцсан салбар, нэгжийнхээ үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллана	төрийн бодлого шийдвэр хууль тогтоомжийг хэрэгжүүлэн сурталчилан таниулах үйл ажиллагааг явуулж төрийн албаны үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд хүргэж, иргэд, удирдлагуудыг мэдээлэлээр шуурхай үйлчилж ажилласан байна. Хэрэгжилт 95,6%	2,010,789.6	1,825,878.5
3	70106- Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	Хоршооны үйл ажиллагааг дэмжин ажиллах	төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан 2 хоршоо, 1 иргэнд зээл олгон ажилласан байна. Хэрэгжилт 43,1%	140,000.0	60,316.0

4	71802-Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	Энэ хичээлийн жилд 75 хүүхдийн дотуур байр ашиглалтад оруулж сурагчдын сурч боловсрох таатай орчин бүрдүүлэн ажиллана	Хэрэгжилт 100%	183,143.1	171,285.7
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	БШУЯ-наас гаргасан чиглэлийн дагуу хүүхдийг зайны сургалтанд 94%-тай хамруулан агуулгын хоцрогдлыг нөхөн ажиллана.	Мөн багшийн хөгжилд анхааран сургалт зөвлөгөөнд хамруулан ажиллаж боловсролын үнэлгээгээр 98%	44,229.4	37,820.7
6	71702-Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Соёл урлагийн олон талт үйл ажиллагаа болон нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	Соёл урлагийн олон талт үйл ажиллагааг сурталчилах ажлыг 3 удаа зохион байгуулан, хэрэгжилт	113,535.6	113,228.7
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01 2023.12.31	Хэрэгжүүлж байгаа 9 хөтөлбөр, 3 бодлогын хүрээнд НЭМ-ийн тусламж үйлчилгээ үзүүлж сургалт сурталчилгаа хийнэ.	хэрэгжилт 100%-тай байна.	44,958.7	36,724.3
8	71403-Ойн анги	2023.01.01 2023.12.31	Ойн анги нь 1 зорилт 1 арга хэмжээ	Хэрэгжилт 85,2%	89,344.6	76,092.0
9	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01 2023.12.31	Сумын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэх	ОНХСангийн төсөл хөтөлбөрөөр 8 хөрөнгө оруулалтын ажил, 2 хөтөлбөр хэрэжин ажиллсан байна.	1,082,438.8	696,827.7

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Хоршоо хөгжүүлэх сангийн хөтөлбөр хэрэгжээгүй нь 87,069.0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдээгүйгээс шалтгаалжээ. Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр 64.4% хэрэгжсэн нь тодотголоор төрийн албан хаагчдын орон сууц барих, зураг төсөв нь эрэмбэд ороогүй, сумын 100 жилийн ойн тэмдэглэх хандив төлөвлөсөн хэмжээнээс 226,663.8 мянган төгрөгөөр бүрдээгүйгээс шалтгаалжээ.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 522,637.4 мянган төгрөгөөр 49 нэр төрлийн тоног төхөөрөмж, бараа ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар, ерөнхий гэрээгээр 35,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нээлттэй тендер шалгаруулалтаар 985,172.3 мянган төгрөгийн 6 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээ, тендер оролцогч шалгаруулах журмаар 96,463.6 мянган төгрөгийн төрийн албан хаагчдын орон сууц барих ажил, 779,635.9 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг тендер шалгаруулалтын онцгой журмаар шууд гэрээ байгуулах болон харьцуулалтын аргаар цахим тендер зарлан худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 976,607.3 мянган төгрөгийн хөрөнгийг шууд худалдан авалтаар, цахим дэлгүүрээс ерөнхий гэрээгээр 33,865.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмж, 1,588,436.9 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг тендер зарлаж худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын татварын орлогын бүрдүүлэлт, биет бус хөрөнгө данс бүртгэлд тусгахтай холбоотой зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 05/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2023 оны төсвийн суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 3,801,362.2 мянган төгрөгийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 57,020.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 42,765.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн жилд цалин хөлс, НДШ-ийн зардал 12,101.6 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 38,472.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 508.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 428.2 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 13.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 6,385.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 88,359.3 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 2.0 мянган төгрөг, хөрөнгийн зардал 507,697.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 178 мэдээлэл байршуулахаас 177 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 1 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,319,698.9 мянган төгрөгийн 56 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 498,188.2 мянган төгрөгийн 23 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 1,381,661.2 мянган төгрөгийн 48 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 50 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна.

#### 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг дарга тайлант онд мод бэлтгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуй нэгж байгууллагатай 47,000.0 мянган төгрөгийн нийгмийн хариуцлагын гэрээг байгуулснаас 7 аж ахуй нэгж байгууллага гэрээний үүргээ биелүүлж 100,0 хувь буюу 47,000.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн байна.

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нэмэлт санхүүжилттэй холбоотой 1 төлбөрийн акт, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт, шилэн данстай холбоотой 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 05/57 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт			Биелэлт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,483.9	1	3,483.9	100

<b>Албан шаардлага</b>					100
<b>Зөвлөмж</b>	2	357,770.7	2	357,770.7	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>361,254.6</b>	<b>3</b>	<b>361,254.6</b>	<b>100</b>

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар ОНХС-ийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудлыг гүйцэтгэлийн аудитаар авч үзнэ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 764,351.1 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 764,351.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

#### 5.2 Зөвлөмж

##### 1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд улсад төвлөрүүлэх 2 нэр төрлийн орлогыг 4,529.5 мянган төгрөг, орон нутагт төвлөрүүлэх 5 нэр төрлийн орлогыг 673,873.6 мянган төгрөгөөр нийт 678,403.1 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх.

##### 2. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

2. Газрын мэдээллийн санд бүртгэлтэй сумын Засаг даргын захирамжаар олгогдсон газрыг тулган шалгахад 85,948.0 мянган төгрөгийн 7 газар данс бүртгэлд тусгагдаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн 2.5.1-д “Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй “газар эзэмших эрх”-ийн асуудлыг шийдвэрлүүлэхэд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ, кадастрын зураг, тухайн газар дээр барилга, байгууламжийн жагсаалт, газар шилжүүлэх болсон үндэслэл, шалтгааны тайлбар” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд тусгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Ойн анги	1	1			1			
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>4</b>		<b>2</b>			

## 7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/										
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	2,470.8	1	2,470.8			1	2,470.8		
Засаг даргын Тамгын газар	1	2,736.5	1	2,486.5			1	2,736.5		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>5,207.3</b>	<b>2</b>	<b>5,207.3</b>			<b>2</b>	<b>5,207.3</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/									
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Засаг дарга	2	764,351.1						2	764,351.1
Засаг даргын Тамгын газар	3	135,350.8	1	9,593.5	1	112,407.6		1	13,349.7
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	2,525.3	1	2,525.3					
Хоршоо хөгжүүлэх сан	1	218,521.4						1	218,521.4
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>1,120,748.6</b>	<b>2</b>	<b>12,118.8</b>	<b>1</b>	<b>112,407.6</b>		<b>4</b>	<b>996,222.2</b>